



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Хулд сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДУА-2024/03/НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Дундговь аймаг 2024 он</p>	<p>Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох Утас: 70592439 Цахим хаяг: <a href="mailto:Munkhtogtokhr@audit.gov.mn">Munkhtogtokhr@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Х.Наранцацрал Утас: 70592225 Цахим хаяг: <a href="mailto:Narantsatsralkh@audit.gov.mn">Narantsatsralkh@audit.gov.mn</a></p> <p>Ахлах аудитор: Д.Ихбаяр Утас: 70593113 Цахим хаяг: <a href="mailto:ikhbayard@audit.gov.mn">ikhbayard@audit.gov.mn</a></p> <p>Аудитор: Ж.Угтахбаяр Утас: 70593113 Цахим хаяг: <a href="mailto:Ugtakhbayarj@audit.gov.mn">Ugtakhbayarj@audit.gov.mn</a></p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

.....	0
1.Аудитын санал дүгнэлт .....	2
2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	6
5. Аудитын илрүүлэлт .....	7
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....	16

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан

## 1. Аудитын санал дүгнэлт



### ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын орлон, 7-р баг, Сайншаган сум  
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,  
70592208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

### ДУНДГОВЬ АЙМГИЙН ХУЛД СУМЫН ЗАСАГ ДАРГА П.БЯМБАЛХАГВА ТАНАА

2024-03-25 № 118  
тантай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Дундговь аймгийн Хулд сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Хулд сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант оны эхнээс орон нутагт ажиллаж байгаа төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл олгож эхэлсэн, Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 2023 оны 07 сарын сарын 01-ээр төрийн албаны үндсэн цалинг нэмсэнтэй холбоотой цалингийн зардал өмнөх оноос 1.3 дахин өссөн, ахмадын сангийн үлдэгдлийг тухайн төсвийн байгууллагын хөтөлбөр арга хэмжээ болгон тайлагнадаг болсон. Мөн 2023 онд Хулд сумын түүхт 100 жилийн ой баяр наадам тохиож, талбайн тохижилтын аж ахуйн эд зүйлс нэмэгдэн бараа материалын дансны үлдэгдэл 1.4 дахин өссөн байна. Уг үйл явдлыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

#### Аудитын гөл асуудал

Дундговь аймгийн Хулд сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн Засаг даргын Тамгын газар өмнөх аудитаар өгөгдсөн шилэн дансны тухай хууль тогтоомжийн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй мөн орон нутгийн хөгжлийн сангийн аудитаар “Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний угсралтын ажилд захиалагчийн хяналт хэрэгжүүлэхтэй холбоотой зөрчлийг арилгах “хугацаатай албан шаардлага”-ын биелэлтийг

хангаагүй, зөрчлийг давтан гаргасан, 2023 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөлтийг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй, (Зураг төсөвгүй, техник, эдийн засгийн үндэслэлтэй, хуульд заасан бусад шаардлага хангаагүй) хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй "өгсөн албан шаардлагын хэрэгжилтийг хангаагүй зөрчил нь тайлант үеийн өндөр үнэлэгдсэн эрсдэлтэй асуудал байлаа.

#### **Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилт, 34 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 77.3 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

## 2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	526,251.2	777,869.1
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	248,631.6	230,932.5
33	АВЛАГА	166,206.4	364,834.3
35	БАРАА МАТЕРИАЛ	98,413.2	137,042.4
36	НӨӨЦИЙН БАРАА	0.0	25,140.0
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	13,000.0	19,920.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,057,419.7	1,132,093.1
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,057,419.7	1,132,093.1
39200	Биет хөрөнгө	1,036,472.6	1,105,960.9
39300	Биет бус хөрөнгө	20,947.2	26,132.2
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,583,670.9	1,909,962.2
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	43,831.1	36,085.4
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	43,831.1	36,085.4
41300	Өглөг	43,818.1	36,085.4
41400	Урьдчилж орсон орлого	12.9	0.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,539,839.8	1,873,876.8
51	Засгийн газрын хувь оролцоо	1,539,839.8	1,873,876.8
51100	Засгийн газрын оруулсан капитал	328,008.3	328,008.3
51200	Хуримтлагдсан үр дүн	881,405.0	1,216,391.9
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	330,426.6	329,476.6
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,583,670.9	1,909,962.2

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,083,748.1	1,747,359.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО	198,361.2	239,718.6
110	Орлогын албан татвар	138,777.4	165,127.1
1100	Хувь хүний орлогын албан татвар	138,777.4	165,127.1
113	Хөрөнгийн албан татвар	52,490.0	60,207.1
118	Бусад татвар, төлбөр, хураамж	7,093.9	14,384.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	147,393.4	387,414.4
120	Нийтлэг татварын бус орлого	147,393.4	387,414.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	737,993.4	1,120,226.6
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	910,276.8	1,073,930.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	910,276.8	1,073,930.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	595,005.0	786,913.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	262,001.0	361,052.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,238.8	43,208.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,047.0	27,493.4
2104	Хангамж, бараа материалын зардал	52,109.1	60,710.7
2105	Нормативт зардал	0.0	650.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,916.3	27,006.8
2107	Томиллот, зочны зардал	3,954.0	13,657.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,603.1	29,816.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	202,135.8	223,316.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	315,271.8	287,016.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	0.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	173,471.4	673,429.4
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,374,592.5	408,824.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-3,201,121.2	264,605.4

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,932,218.2	4,932,218.2
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-191,257.2	-191,257.2
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,740,961.0	4,740,961.0
9	Тайлант үеийн үр дүн	-3,201,121.2	-3,201,121.2
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,539,839.8	1,539,839.8
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,539,839.8	1,539,839.8
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	70,381.6	70,381.6
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,610,221.4	1,610,221.4
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-950.0	-950.0
19	Тайлант үеийн үр дүн	264,605.4	264,605.4
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	1,873,876.8	1,873,876.8

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	1,092,700.5	1,590,637.9
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	198,361.2	239,718.6
110	Орлогын албан татвар	138,777.4	165,127.1
1100	Хувь хүний орлогын албан татвар	138,777.4	165,127.1
113	Хөрөнгийн албан татвар	52,490.0	60,207.1
118	Бусад татвар, төлбөр, хураамж	7,093.9	14,384.4
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,598.2	6,163.8
1181	Газрын төлбөр	3,495.7	7,720.5
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	0.0	500.0
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	160,420.0	230,976.8
120	Нийтлэг татварын бус орлого	160,420.0	230,976.8
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	733,919.3	1,119,942.6
II	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	783,964.5	994,307.2
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	783,964.5	994,307.2
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	732,955.1	976,372.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	314,959.4	362,090.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,893.1	43,208.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	212,026.7	65,694.3
2104	Хангамж, бараа материалын зардал	34,229.8	63,101.8
2105	Нормативт зардал	90.0	650.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,651.0	31,420.4
2107	Томилолт, зочны зардал	5,454.0	13,657.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,230.2	265,612.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	92,420.9	130,937.0
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	51,009.4	17,934.6
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	308,736.0	596,330.7
V	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	245,039.1	499,029.8
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	245,039.1	499,029.8
2200	Дотоод эх үүсвэрээр	245,039.1	499,029.8
VI	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	-245,039.1	-499,029.8
VII	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	-79,000.0	-115,000.0
23	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	79,000.0	115,000.0
VIII	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	-15,303.2	-17,699.1
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	263,934.8	248,631.6
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	248,631.6	230,932.5

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,753,444.6	1,535,938.3
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	969,249.5	925,908.6
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	954,899.5	911,558.6
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	370,937.3	362,090.3
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	51,846.0	43,208.9
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	270,206.9	270,066.9
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	48,836.0	48,623.4
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	650.0	650.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	53,807.8	53,750.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	13,781.0	12,416.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	11,653.0	10,439.8
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	133,181.5	110,313.3
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	14,350.0	14,350.0
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	14,350.0	14,350.0
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	611,695.1	495,029.8
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	172,500.0	115,000.0
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,753,444.6	1,481,137.8
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	427,043.3	427,043.3
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	964,048.0	943,445.0
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	362,353.3	110,649.5
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	125,000.0	66,905.1
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	56,293.8	43,744.4
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	181,059.5	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	185,376.1
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	130,575.5

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	72,141.3
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	72,141.3
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	68,814.1
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	300.0
210303	Цэвэр, бохир ус	300.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	14,478.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	909.8
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	7,166.3
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,241.9
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	25,003.8
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	20,623.7
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	3,327.2
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	3,327.2
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	3,327.2
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	72,141.3
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	72,141.3
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,857.3
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	53,284.0

## 5. Аудитын илрүүлэлт

### 5.1 Сумын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 24,348.8 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 24,348.8 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлсэн.

#### 5.1.1 Албан шаардлага

1. Аудитаар Хулд сумын орон нутгийн татварын 11 нэр төрлийн орлогыг төвлөрүүлэхээс 5 нэр төрлийн 24,348.8 мянган төгрөгийн татварын орлогыг төвлөрүүлээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй зөрчил илэрсэн. Энэ нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.19-т /Нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах/, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т /Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ/, 41.2.1-т /Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх/ заасныг тус тус зөрчсөн байна.

### 5.2 Сумын нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсвийн шүүд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 6 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 1 байгууллага, 4 сан түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна.

Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл:

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	Засаг даргын Тамгын газар	1	1			1			
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	1		1					
3	Мал хамгаалах сан	1		1					
4	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
5	Орон нутгийн хөгжлийн	1		1					
6	Байгаль хамгаалах сан	1		1					
	<b>НИЙТ</b>	6	1	5		1			

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 270,489.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 34,853.4 мянган төгрөгийн 6 алдааг аудитын явцад залруулж, 4,020.3 мянган төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 231,616.1 мянган төгрөгийн 10 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн байна.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 12.8 хувийг залруулагдаагүй, 87.2 хувийг залруулсан алдаа эзэлж байна.

#### Дүгнэлтийн үндэслэл, тайлбар

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Нийт 235,636.4 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчлийн 94.3 хувь буюу 222,197.9 мянган төгрөг нь нийцлийн аудитын асуудал, үлдсэн 5.7 хувь нь 13,438.5 мянган төгрөг нь санхүүгийн тайлангийн аудитын зөрчил илэрчээ. Мөн Сумын Засаг даргын нэгтгэсэн тайлангаар илэрсэн 24,348.8 мянган төгрөгийн зөрчил нь нийцлийн аудитын асуудал байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулахдаа боломжгүй, аудитын дүгнэлтэд нөлөөлөх 16,108.9 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг түвшингээс 2,670.4 мянган төгрөгөөр буюу 16.6 хувиар бага байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



Дундговь аймгийн Хулд сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Орон нутгийн хөгжлийн сан	4	219,546.0			2	219,546.0			2		
Хоршоо хөгжүүлэх сан	1.0	2,651.9	1	2,651.9							
Засаг дарга	1	24,348.8			1	24,348.8					
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>246,546.7</b>	<b>1</b>	<b>2,651.9</b>	<b>3</b>	<b>243,894.8</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>Нийт дүн</b>	<b>8</b>	<b>246,546.7</b>	<b>1</b>	<b>2651.9</b>	<b>4</b>	<b>243,894.8</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>3</b>	<b>0</b>	<b>0</b>

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	2	1	1		1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС	4		4					
4	ТТЗ	1	1			1			
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>7</b>	<b>2</b>	<b>5</b>		<b>2</b>			